



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2009 оны II улирал. №02

Энэхүү тойм нь улирал бүр гаргаж буй тайлангийн товчлол юм.
Дэлгэрэнгүй тайланг www.forum.mn сайтаас харна уу

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө

Оршил

2008 онд 8.9 хувийн өсөлттэй байсан манай улсын эдийн засгийн өсөлт ч эрс саарч 2009 онд 2.7 хувиар өсөх урьдчилсан төлөвтэй байгаа.

Өнгөрсөн оны сүүлийн улиралд өсөлт үлэмж саарсан нь эрдэс баялгийн үнэ буурч, хямралын нөлөө мэдрэгдэж эхэлснийг илтгэж байсан. Энэ оны эхний улиралд ДНБ өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4.2 хувиар буурсан байна.

Дэлхийн санхүүгийн хямрал үргэлжилж байна. Эхний хагас жилийн байдлаар өндөр хөгжилтэй орнуудад өсөлтийн шинж тэмдэг илрээгүй хэдий ч хямрал нэгэнт доод цэгтээ хүрсэн гэж мэргэжлийн хүмүүс дүгнэж байна. Азийн бүс нутагт эдийн засгийн өсөлт хурдасч, байдал нэлээд сайжирч байгаа ч макро эдийн засгийн албан ёсны статистикийн үзүүлэлтүүд эерэг болно гэдэг нь хүмүүсийн амьдрал сайжирсныг шууд илэрхийлэхгүй юм. Ялангуяа орлого багатай иргэдэд хямралын хүндрэл хэсэг хугацаанд үргэлжлэх нь дамжиггүй. Энэ хандлага нь буурай хөгжилтэй орнуудад илүү хүчтэй байна.

Энэ хямрал дэлхийн эдийн засагт томоохон бүтцийн өөрчлөлт авчирна гэж олон эдийн засагчид үзэж байна. Сүүлийн хэдэн арван жил хөгжиж ирсэн бүтэц сууриараа өөрчлөгдөх магадлалтай юм. Азийн хурдацтай хөгжиж ирсэн орнууд, тэр дундаа БНХАУ экспортод чиглэсэн аж үйлдвэржилтийн бодлогыг олон жил хэрэгжүүлсний үр дүнд АНУ болон БНХАУ хоёрын хооронд гадаад худалдааны томоохон тэнцвэргүй байдал бий болсон. Цаашдаа энэхүү хандлага үргэлжлэх боломжгүй гэдэг нь улам бүр тодорхой болж байна.

Хэдхэн хоногийн өмнө Вашингтон хотноо болсон АНУ болон БНХАУ-ын хоёр талын стратеги, эдийн засгийн уулзалтын үеэр АНУ-ын албаны хүмүүс БНХАУ цаашид АНУ-ын өрх гэрийн өндөр хэрэглээнд тулгуурлан үргэлжлүүлэн өсөх боломж үгүй болж байгаа талаар цохон тэмдэглэсэн байна. Иймээс Хятадын хувьд богино хугацаандаа энэхүү хямралаас гарах, дунд болон урт хугацаандаа өндөр өсөлтөө баталгаажуулах цорын ганц арга бол дотоодын хэрэглээний өсөлт юм гэдгийг сануулсан байна. Хятадын Засгийн газар энэхүү байдлыг ойлгож байгаа бөгөөд анхны алхмуудаа авч эхлээд байна. Хятад дэлхийн томоохон хэрэглээний зах зээл болж хувирах нь. Ийнхүү Хятадын дотоодын хэрэглээ өсөх нь манай экспортод сайнаар нөлөөлөх нь ойлгомжтой. Тиймээс манай эдийн засгийн дунд хугацааны төлөв тун сайн байна. Харин богино хугацаанд байдал хүнд хэвээр байх магадлалтай байна.

Монголын эдийн засаг хямралтай хэвээр байгаа хэдий ч макро эдийн засгийн тогтворжилтын зарим шинж тэмдгүүд 2009 оны хоёрдугаар улиралд илэрч байна.

- Бодит ДНБ тайлант оны эхний улиралд 4.2 хувиар буурсан. Хоёрдугаар улирлын ДНБ-ий үзүүлэлт хараахан гараагүй боловч бодит үйлдвэрлэл, үйлчилгээний салбар хүндхэн байгаа нь тодорхой байна.
- Аж үйлдвэрийн салбар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.9 хувиар буурсан. Үүнд, боловсруулах салбарын үйлдвэрлэл 22.6 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.
- Хөдөө аж ахуйн салбар, тэр дундаа үр тарианы салбар 2009 онд тогтвортой байхаар хүлээгдэж байна. Үр тариалалт хийсэн талбай өмнөх оны мөн үеэс 47 хувиар их байгаа бөгөөд мал аж ахуй тогтвортой байна.
- Барилгын салбар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.2 хувийн уналттай байна.
- Гадаад худалдаа эрс буурсан дүнтэй байна. Экспорт, импортын хэмжээ 36-45 хувиар буурчээ. Харин гадаад худалдааны алдагдал 130 сая ам. доллар байгаа нь өмнөх оны мөн үеэс бараг дөрөв дахин бага байна.
- Эдийн засгийн хямралтай тэмцэх зорилгоор ОУВС-тай хамтран Засгийн газар, Монголбанк Стэнд-бай хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Ерөнхийдээ тус хөтөлбөр нь биелүүлэхэд хүндрэлтэй тоон зорилтууд багатай, Засгийн газар болоод Монголбанкны үйл ажиллагаанд шууд хутгалдан орох заалтууд цөөн, цомхон, хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь тодорхой байгаа нь сайшаалтай. Гэвч өнөөг хүртэл авч хэрэгжүүлж ирсэн зарим бодлогын арга хэмжээн дээр анхаарах зүйлс байгаа.
- Сүүлийн саруудад дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ тогтворжиж, өсч эхэлж байгаатай холбоотойгоор Засгийн газрын төсвийн цаашдын чиг хандлагад эерэг нөлөө үзүүлж эхэллээ. Төсвийн алдагдал 6 дугаар сарын байдлаар 264 тэрбум төгрөг байна.
- ОУВС-тай хөтөлбөр тохирсонтой холбоотойгоор дэлхийн санхүүгийн байгууллагууд, донор орнууд одоогийн байдлаар 160 сая ам. долларын зээлийг төсвийн алдагдлыг нөхөхөд олгох боломжтой гэдгээ мэдэгдсэн.
- Төсөв, сангийн бодлогыг эдийн засгийн мөчлөгийн эсрэг болгох нь чухал байна.
- Инфляцийн түвшин буурч 4.7 хувьд хүрчээ. Сүүлийн гурван сарын байдлаар гадаад валютын ханш тогтвортой байсан.
- Мөнгөний бодлого үнийн өсөлтийг дунд болоод урт хугацаанд бага түвшинд барихыг зорьж байх нь чухал байна.

Дотоодын үйлдвэрлэл

Дэлхий нийтээр байдал сайжрах эхний шинж тэмдэг байгаа хэдий ч өсөлтийн тухай ярих эрт байна. Дэлхийн Банкнаас 2009 оны 5 дугаар сард шинэчлэн гаргасан тооцоогоор дэлхийн эдийн засаг 2009 онд 2.9 хувиар буурах бөгөөд ингэхдээ хөгжингүй орнуудын эдийн засаг 4.2 хувиар буурч, хөгжиж буй орнуудын эдийн засаг дөнгөж 1.2 хувиар өсөхөөр байна. Энэхүү тооцоогоор хөгжиж буй эдийн засгийн өсөлтийн хэмжээ өмнөх таамаглалаас буурсан дүнтэй байгаа юм. 2008 онд 8.9 хувийн өсөлттэй байсан манай улсын эдийн засгийн өсөлт ч эрс саарч 2009 онд 2.7 хувиар өсөх урьдчилсан төлөвтэй байгаа. Өнгөрсөн оны сүүлийн улиралд өсөлт үлэмж саарсан нь эрдэс баялгийн үнэ буурч, хямралын нөлөө мэдрэгдэж эхэлснийг илтгэж байсан. Энэ оны эхний улиралд ДНБ өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4.2 хувиар буурсан байна


(Зураг 1)¹. Энэ тооноос харахад бодит эдийн засаг энэ онд эерэг өсөлттэй байх магадлал муу гэж үзэж байна.

2009 оны эхний хагас жилд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар буураад байгаа. Энэхүү бууралтад боловсруулах салбар 22.6 хувь, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 1.6 хувиар буурсан нь нөлөөлжээ. Энэ нь манай улсын аж үйлдвэрийн салбар, тэр дундаа боловсруулах үйлдвэрлэл нэлээд хүндхэн байдалд байгааг харуулж байна.

Цаашилбал, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн борлогдоогүй үлдсэн хүнсний гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүн, тэр дундаа мах, гурил, жигнэмэгийн хэмжээ нэмэгдсэн байна. Тухайлбал, махны үйлдвэрлэл 2009 оны эхний хагаст өнгөрсөн оны

¹ Энэхүү тайланг бичих үед 2009 оны хоёрдугаар улирлын ДНБ-ий өсөлтийн тоо хараахан гараагүй байв.

Зураг 1. ДНБ – ий өсөлт улирлаар,
өмнөх оны мөн үетэй
харьцуулахад



Эх сурвалж: УСХ, 2009 оны 1, 4-р сарын бюллетень

мөн үетэй харьцуулахад 94.5 хувиар буурсан байхад агуулахад борлогдоогүй үлдсэн махны хэмжээ 1.7 дахин их байна. Ийнхүү аж үйлдвэр унаж, тэр дундаа дотоодын нийлүүлэлтийг хангадаг чухал салбар болох боловсруулах салбарын үйлдвэрлэл огцом буурч, хөдөлмөрийн бүтээмж буурсан зэргээс аж үйлдвэрийн салбар бүхэлдээ хүнд байдалд хэвээр байгаа дүр зураг харагдсаар байна. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хөдөлмөрийн бүтээмж, гол нэр төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээ энэ онд өмнөх оны мөн үеийн үзүүлэлтээс буурсан хэвээр байгаа нь гадаад болон дотоодын эрэлтийн бууралтаас голлон шалтгаалсан бөгөөд нийт эрэлт ийнхүү үргэлжлэн буурч байгаа нь манай улсын дотоодын үйлдвэрлэлд цаашид ч сөргөөр нөлөөлөхөөр байна.

Мал аж ахуйн хувьд байдал мөн хүнд хэвээр байна. 2009 оны эхний хагас жилд 14.8 сая эх мал буюу нийт төллөх малын 79.9 хувь төллөсөн ба төллөсөн малын тоо 2007 ба 2008 оны мөн үеэс өссөн ч төл бойжилт 91.6 хувьтай байгаа нь 2007 оны мөн үеэс 6.6 пункт, 2008 оны мөн үеэс 0.6 пунктээр буурсан үзүүлэлт юм. Тэгвэл зүй бусаар хорогдсон малын тоо 2009 оны эхний хагас жилд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1,437.9 мянган толгойд хүрч 1.5 хувиар их байна.

Махны үйлдвэрлэл 2009 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үетэй харьцуулахад ихээхэн

унасан, хөдөө аж ахуйн түүхий эдийн үнэ тэр дундаа хонины арьс, үхрийн шир, адууны шир зэргийн үнэ өмнөх оны мөн үеэс эрс унасан хэвээр байна. Ямааны махны үйлдвэрлэл өссөн нь илүү үнэтэй үхэр, хонины махыг хямд махаар орлуулж буй хэрэглэгчдийн үйл хөдлөлийн үр дүн гэж үзэж байна. Түүхий эдийн үнэ огцом унасан, гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт буурсан зэргээс мал аж ахуйн салбар хүнд цохилтод нэрвэгдээд байна.

Улсын хэмжээгээр 2009 оны эхний зургаан сард 280.3 мянган га талбайд тариалалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс даруй 47.3 хувиар их байгаагаас үр тариа, буудай, төмс, хүнсний ногооны тариалалт 3.5 – 67.7 хувиар өндөр байна. Тариалсан талбайн хэмжээ ийнхүү нэмэгдсэн нь сайшаалтай боловч газар тариалангийн ажлын үр өгөөжийг үнэлэх нь хараахан эрт байна.

Үйлчилгээний тэнцэл (гадаадын иргэдэд үзүүлсэн үйлчилгээ болон гадаадаас худалдаж авсан үйлчилгээний зөрүү) 2008 оны сүүлийн улиралд 66.7 сая ам.долларын алдагдалтай гарсан бөгөөд үүнд тээврийн үйлчилгээний алдагдал гол нөлөө үзүүлсэн. 2009 оны эхний хагаст тээврийн салбарын нийт орлого өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар буурчээ. Үйлчилгээний салбарын бууралт нь эрэлтийн хүчин зүйлээр өдөөгдөж тэдгээрийн нийлүүлэлт ийнхүү буурсаар байна. Тэгэхдээ тус салбарын бууралт нь дотоодын төдийгүй гадаадын хэрэглэгчдийн эрэлтийн бууралтаар нөхцөлдөж байгаа. Манай улсад 2009 оны эхний хагас жилд гадаадын 158.3 мянган зорчигч орж ирсэн нь өмнөх оны мөн үеэс 18.4 хувиар буурсан бол жуулчлалын зорилгоор ирсэн зорчигчид нь 35.2 хувиар буураад байна. Зарим нэр төрлийн үйлчилгээ, тухайлбал шуудан, харилцаа холбоо зэрэг нь өсөлттэй байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Тэгвэл, 2009 оны эхний хагаст төмөр замаар болон агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо 2008 оны мөн үеийнхээс 28 болон 29.4 хувиар тус тус буурсан байна. Агаарын тээврээр дотоодод зорчсон зорчигчдын тоо мөн хугацаанд 46.7 хувиар буурчээ. Төмөр

зам, агаарын тээврээр үйлчлүүлсэн зорчигчдын тоо төдийгүй тээвэрлэсэн ачааны хэмжээ ч буурсан байна. Мөн хугацаанд төмөр замын тээврээр тээвэрлэсэн ачаа 9.1 хувиар, агаарын тээврийнх 45 хувиар буурчээ. Ингэснээр төмөр замын тээврийн салбарын орлого өмнөх оны мөн үеэс 0.5, агаарын тээврийнх 30 хувиар буураад байна.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 60 гаруй хувийг эзэлдэг, манай эдийн засгийн чухал салбар болох уул уурхай олборлох аж үйлдвэрийн өсөлт нь дэлхийн зах зээл дэх эрдэс баялгийн үнээс шууд хамаардаг. Тухайлбал, нэг тонн зэсийн үнэ 2009 оны 3 дугаар сард 3,500 ам. доллар болж, тус салбарын үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.8 хувиар буурсан. Тэгвэл, энэ оны 3 дугаар сараас эхлэн дэлхийн зах зээлд зэсийн үнэ аажмаар өсч, эхний зургаан сарын дунджаар 4,046 ам.доллар болж, өнгөрсөн оны 12 дугаар сарын дунджаас даруй 37.1 хувиар нэмэгдсэн нь тус салбарын 2009 оны эхний хагас жилийн үйлдвэрлэлийн бууралтыг эрс багасгаж, 1.6 хувьд хүргэсэн байна. Ийнхүү тус салбарын үйлдвэрлэлийн бууралтын хэмжээ багассан нь ашигт малтмалын үнэ ханшны эерэг өөрчлөлттэй шууд холбоотой. ДНБ болон нийт экспортын орлого төдийгүй төсвийн орлогын (2007 онд 39.0 хувь байсан) томоохон хэсгийг уул уурхай олборлох үйлдвэрлэл бүрдүүлдэг манай улсын нийт эдийн засагт энэ нь эерэг хандлагыг бий болгож байна.

2009 оны эхний хагас жилд уул уурхайн салбарын үйлдвэрлэл буурахад зэс, цайр, хайлуур жонш, алт, гянтболдын баяжмал зэргийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 0.6-50.2 хувиар буурсан нь сөрөг нөлөө үзүүлжээ. Дээрх бүтээгдэхүүнээс дэлхийн зах зээлд үнэ нь өсөлттэй байгаа алтны үйлдвэрлэл 2009 оны эхний хагаст өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.6 хувийн бууралттай байгаа нь алтны том олборлогч Бороо Гоулдын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотой байх магадлалтай юм.

2009 оны эхний хагас жилд барилгын салбарын үйлдвэрлэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 38.2 хувиар буурсан байна. Энэхүү

бууралтад орон сууцны барилга 35.1 хувь, худалдаа үйлчилгээний барилга 46.6 хувиар буурсан нь гол нөлөө үзүүлжээ. Сүүлийн жилүүдэд өндөр өсөлттэй байсан барилгын салбарын үйл ажиллагаа ийнхүү уналтад ороход тус салбарын зарим аж ахуйн нэгж санхүүгийн эх үүсвэргүй болсноос өнгөрсөн оны сүүлийн улирлаас эхлэн үйл ажиллагаагаа зогсоосон, мөн оны дунд үеэс барилгын зарим гол нэрийн барааны үнэ огцом өссөн зэргээс үүдэлтэй. Бараа материалын үнэ өссөнөөс өндөр өртөгтэй бий болсон барилгаа борлуулж чадахгүй байгаа нь тус салбарын уналтад нөлөөлж буй хүчин зүйлүүдийн нэг билээ. 2009 оны эхний хагас жилд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад барилгын бүх төрлийн байгууллагын барилга угсралт, их засварын ажил буурсан бөгөөд бууралтын хэмжээ 23.3–53.6 хувьтай байна. Гадаадтай хамтарсан барилгын байгууллагын уналт хамгийн бага буюу 23.3 хувьтай байгаа юм.

Дэлхийн Банкнаас 2009 оны 2 дугаар сард гаргасан манай улсын улирлын эдийн засгийн тоймд дурдахдаа дотоодын хүчин зүйлээр өдөөгдсөн орон сууцны үнийн хөөрөгдөл туйлдаа хүрч задарсан нь барилгын салбарт олгосон зээлийн багцад сөргөөр нөлөөлсөн гэж онцолсон билээ. Барилгын салбарын энэхүү хүндрэлтэй байдлаас гарахын тулд богино хугацаанд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ баригдсан барилгыг зах зээлд хурдан борлуулж эргэлтийн хөрөнгөө сайжруулах шаардлага байсаар байна.

Дотоодын үйлдвэрлэлийн аж үйлдвэр, ХАА болон үйлчилгээний салбарын талаарх 2009 оны эхний хагас жилийн тоон мэдээнээс харахад оны эхний улирлын үзүүлэлтүүдээс байдал арай сайжирсан байгаа нь улирлын шинж чанартай идэвхжлийн үр дүн гэж үзэж байна. Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн өсөлт уул уурхай олборлох салбарын үйлдвэрлэлийн уналтыг нэлээд хэмжээгээр зөөллөж өгсөн нь нийт эдийн засагт эерэгээр нөлөөлсөн нь харагдаж байна. Цаашдаа дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт төрийн зүгээс үзүүлэх дэмжлэг нь хөрөнгө оруулалт, шууд татаас эсвэл татварын

хөнгөлөлтөөс илүүтэйгээр үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогыг баримтлах нь илүү чухал тухай бид өмнөх улирлын тайланд дурьдсан байгаа.

Бодит эдийн засаг уул уурхайн салбараасаа хэт хараат болох нь тухайн улсын эдийн засаг бүхэлдээ гадаад зах зээл дэх эрдэс баялгийн үнээс хараат болж байгааг илэрхийлнэ. Гадаад зах зээл дэх үнэ тогтворгүй байх тусам тухайн улсын эдийн засаг тогтворгүй байна. Эдийн засгийн тогтворгүй орчин нь тодорхой бус байдлыг бий болгодог учир үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх сонирхол хувь хүн, пүүс компаниудад буурч үйлдвэрлэл, үйлчилгээнд хөрөнгө оруулах сонирхлыг төрүүлдэггүй. Тиймээс, дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээний төрөлжилтийг өргөтгөж, нэг салбараас хэт хараат байдлыг арилгах арга хэмжээ авах нь зүйтэй гэсэн дүгнэлт хийж болох нь. Энэ нь бодит амьдрал дээр хэрэгжүүлэхэд нэлээд төвөгтэй нь ойлгомжтой.

Засгийн газрын өнөөгийн үзэл баримтлалын дагуу стратегийн уул уурхайн томоохон ордуудыг ашиглаж эхэлснээр манай улсын цаашдын хөгжлийн чиг хандлага тодорхойлогдоно гэж үзэж байна. Тухайлбал, уул уурхайгаас орж ирэх хөрөнгийн урсгал өсөхийн хэрээр манай улсын дэд бүтэц хөгжиж, үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөжүүлэх боломжтой болно гэсэн санаа гэж ойлгогдож байна. Үндэсний Хөгжил, Шинэтгэлийн Хорооноос танилцуулж байгаагаар эдгээр орд газруудыг түшиглэн уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах, эрчим хүч, тээвэр, химийн үйлдвэрлэл, нано-технологии, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт, биотехнологи, мэдээллийн технологи зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудыг хөгжүүлж, давуу тал бий болгож болно гэж үзжээ. Цаашилбал, тус хороо нь нэмэгдсэн өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж, хөгжих бололцоог нь хангаж өгөх зорилго тавьж байгаа бөгөөд манай улсын ирээдүйн хөгжилд хувийн сектор тэргүүлэх үүрэг гүйцэтгэнэ гэдгийг онцолсон байна.

Манай орны хувьд байгалийн баялгийг ашиглах нь урт хугацаанд эдийн засгийн өсөлт авчрах салбаруудыг хөгжүүлэх гол шат дамжлага гэж үзэж байгаа. Урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг авчирч, олон нийтийг ажил эрхлэлтээр хангаж, бодит орлогыг дээшлүүлэх боломжийг олгох гол салбарууд бол нэмэгдсэн өртөг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд байх юм. Тийм учраас, уул уурхайн салбарын хөгжил нь манай улсын хөгжлийн эцсийн зорилго биш, харин завсрын шат бөгөөд бид өөрсдийн үйлдвэрлэл, үйлчилгээний давуу талаа олж авахын тулд уул, уурхайгаас орох хөрөнгийн эх үүсвэрийг ашиглах ёстой.

Хэрэв уул уурхайн салбар манай орны бодит эдийн засагт зонхилох үүргийг урт удаан хугацааны турш гүйцэтгэх юм бол манай орон бүх нийтийг хамарсан нийгмийн тэтгэмжийн тогтолцоо руу шилжих магадлалтай байна. Өөрөөр хэлбэл, ард иргэд Засгийн газраас олгож буй тэтгэмжээс хэт хараат болох аюул байна. Байгалийн баялгийн нөөц өөрөө шавхагддаг нөөц учраас иймэрхүү тэтгэмжийн тогтолцоо эдийн засгийн өсөлтийг авчирдаггүй. Эдийн засгийн өсөлт авчрахгүй учраас нийгэм дэх ядуу, баяны ялгаа огцом өсч, нийгмийн тогтворгүй байдлыг үүсгэдэг гэдгийг олон орны түүх харуулсан. Тийм ч учраас эдийн засагчид үүнийг “байгалийн баялгийн хараал” гэж нэрийдэх нь бий.

Манай орны хувьд хэдийгээр эдгээр ордуудыг ашиглалтад оруулах нь томоохон ажил боловч бид энэхүү “хараал”-д өртчихгүй байх нь маш чухал гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй. Дэлхий дээр олон орон энэхүү “хараал”-д өртөн баялгаа ард түмэндээ биш зөвхөн цөөн тооны хүмүүст хүртээж байгаа. Цөөнгүй тооны орон үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ салбарыг амжилттай өргөжүүлж, төрөлжүүлж эрдэс баялгийн салбараасаа хараат бус болсон. Тиймээс бид одооноос гол анхаарлаа өөрсдийн давуу талаа ашигласан нэмэгдсэн өртөг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээний салбар хөгжүүлэхэд анхаарах нь чухал. Үндэсний Хөгжил, Шинэтгэлийн Хорооны боловсруулж буй хөгжлийн стратеги ч үүнийг чухалчилж байгаа нь зүйтэй юм.

Гадаад худалдаа

Монгол Улсын хувьд гадаад худалдаа нь хямралд гүнзгий өртөж байгаа салбаруудын нэг юм. 2008 оны сүүлийн улирлаас эхлэн экспорт, импортын хэмжээ эрс буурсан байдал 2009 оны хоёрдугаар улиралд үргэлжиллээ. 2009 оны эхний хагас жилийн байдлаар манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 1655.7 сая ам доллар, үүнээс экспорт 762.9 сая ам доллар, импорт 892.8 сая ам доллар болсон байна. 2009 оны хоёрдугаар улирлын экспортын хэмжээг өмнөх оны тухайн саруудтай харьцуулахад 36-40 хувиар, импорт 38-45 хувиар буурсан нь Хүснэгт 1-ээс харагдаж байна. 2009 оны эхний улирлын турш экспортын хэмжээний уналт нь импортын хэмжээний уналтаас их байсан бол хоёрдугаар улиралд импортын уналт экспортынхоос яльгүй илүү байна.

Хоёрдугаар улирал хөдөө аж ахуйн барааны ялангуяа ноолуурын экспортын ид үе байдаг. Энэ онд бохир ноолуурын экспорт хэмжээний хувьд нэмэгдсэн боловч үнийн хувьд төдийлөн өссөнгүй. Энэ түвшинг өнгөрсөн оны мөн улиралтай харьцуулбал бохир ноолуурын экспортын үнэ 10 хувиар нэмэгдсэн бол самнасан ноолуурын экспортын үнэ 36 хувиар буурсан байна.

2009 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт импортын хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 579 сая ам. доллар буюу 39 хувиар буурсан байна. Импорт бага байгаа нь манай эдийн засгийн нийт эрэлт өсөхгүй, эдийн засгийн уналт үргэжилсээр байгаатай холбоотой. Манай орны төдийгүй манайхаас түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авдаг гадаад орнуудын эрэлт буурсан хэвээр байна. 2009 оны

хоёрдугаар улиралд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад манайхаас бүтээгдэхүүн худалдан авдаг гол орнуудын эрэлт, тухайлбал Хятадынх 29 хувь, АНУ-ынх 54 хувь, Канадынх 43 хувь, Оросынх 48 хувиар тус тус буурчээ.

Гэхдээ сараар нь авч үзвэл хоёрдугаар улирлын туршид экспортын болон импортын хэмжээ аажмаар нэмэгдэж ирсэн нь манай экспортын гол бараа зэсийн баяжмалын экспортын хэмжээ нь тогтмол байсан боловч үнэ нь аажмаар өсч байгаатай холбоотой (Зураг 2). 2009 оны хоёрдугаар улиралд нийт экспорт аажмаар өссөн нь экспортын гол бараа зэсийн баяжмалын хэмжээ буураагүй, молибдений хүдэр ба баяжмал, төмрийн хүдрийн экспорт өссөн, мөн бохир ноолуур, махны экспорт нэмэгдсэнтэй холбоотой байна. Уг хугацаанд экспорт улам их байх боломжтой байсан. Учир нь 6 дугаар сард алтны экспорт хийгдээгүй тул экспортын үнийн дүнгийн хэмжээ илүү өндөр байж чадсангүй.


Сараар авч үзэхэд хоёрдугаар улирлын туршид импортын хэмжээ аажмаар нэмэгдэж ирсэн нь Зураг 2-оос харагдаж байна. Нийтийн тээврийн хэрэгсэл, суудлын автомашин, ачааны тэрэгний импорт нэмэгдсэн бөгөөд эдгээртэй хослох бүтээгдэхүүн болох бензин, дизель түлшний импорт мөн бага хэмжээгээр нэмэгдсэн байна. 2009 оны эхний улиралд багасаад байсан согтууруулах ундаа, тамхины импорт хоёрдугаар улиралд мөн нэмэгдсэн байна. Харин хүнсний бүтээгдэхүүний импорт буурсан хэвээр байна. Тухайлбал 5 дугаар сард төмсний импорт өмнөх сарынхаас 34 хувиар, цагаан будаа 46 хувиар, элсэн чихэр 60 хувиар, гурил 11 хувиар тус тус буурсан байна. Үнийн болон орлогын мэдрэмж сайтай буюу үнэ нь өсөнгүүт эсвэл орлого

Хүснэгт 1. Гадаад худалдааны өөрчлөлт, хувиар (өмнөх оны мөн үетэй харьцуулахад)

	2008			2009					
	10-р сар	11-р сар	12-р сар	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар
Экспорт	13.3	-43.4	-26.7	-21.3	-71	-38.6	-36.3	-40	-38
Импорт	42.4	63.5	-9.8	-40	-51	-24.3	-45.8	-45	-38.3


Эх сурвалж: УСХ, 2009 оны 6-р сарын бюллетень

Зураг 2. Экспорт ба импортын хэмжээ, 2008 ба 2009 оны эхний 6 сард, сая ам.доллар



Эх сурвалж: УСХ, 2009 оны 6-р сарын бюллетень

Зураг 3. Гадаад худалдааны тэнцэл, сая ам. доллар



Эх сурвалж: Монголбанк, 2009 оны 5-р сарын мэдээ

буурангуут эрэлт нь буурдаг бараа болох бэлэн хувцас, гутал, алт мөнгөн эдлэл зэргийн импорт бага хэвээр байна.

Гадаад худалдааны тэнцэл 2009 оны 4 дүгээр сард 93.4 сая, 5 дугаар сард 101.2 сая ам. долларын алдагдалтай гарлаа. Гэхдээ 2009 оны хоёрдугаар улирлын алдагдлын хэмжээ 2008 оны мөн үеэс бага байна. Хямралын нэг эерэг нөлөө бол гадаад худалдааны тэнцэл хэмжээний хувьд бага алдагдалтай гарч байгаа явдал юм (Зураг 3).

Гэвч хэдийгээр гадаад худалдааны тэнцлийн алдагдлын хэмжээ багассан боловч нийт

экспортын хэмжээ 40 хувиар бага, импортын хэмжээ 39 хувиар бага байгаа нь хямралын гол сөрөг нөлөө юм. Ийнхүү хоёрдугаар улиралд гадаад худалдааны тэнцэл алдагдалтай гарсан нь алтны экспорт буурсан мөн импорт эргээд өссөнтэй холбоотой.

Үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлтүүд гадаад худалдаа, экспортод ихээхэн нөлөөлдөг. 2009 оны эхний хагас жилд аж үйлдвэрлэлийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 8 хувиар, экспортын гол салбар болох уул уурхайн олборлох аж үйлдвэрлэл 1.6

хувиар буурлаа. Тэгвэл 2009 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэсийн экспорт 57, алт 95, цайр 60, жонш 48 хувиар тус тус буурлаа. Өөрөөр хэлбэл, хоёрдугаар улиралд гол түүхий эдийн экспортын уналт нь үйлдвэрлэлийн уналтаасаа илүү байлаа.

Гаалийн татварын орлого 2008 оны хоёрдугаар улиралд 45.1 тэрбум хүрч байсан бол энэ онд 31.1 тэрбум төгрөг болж, 31 хувиар буурсан байна. Импортоор оруулдаг бензин, дизель түлш, архи, тамхи, пиво, машинаас авах онцгой албан татварын орлого 2008 оны хоёрдугаар улиралд 47 тэрбум төгрөг байсан бол энэ онд 49 тэрбум төгрөг болж, хоёр тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийтдээ 2009 оны хоёрдугаар улирлын байдлаар гаалийн болон онцгой албан татварын орлого өмнөх оны мөн үеэс 12 тэрбум төгрөгөөр буурсан нь төсвийн орлогод сөргөөр нөлөөлж байна.

Дүгнэж хэлэхэд хямралын Монголын эдийн засагт нөлөөлж байгаа гол суваг гадаад худалдаа хэвээр байна. Хэдийгээр өмнөх оны байдалтай харьцуулахад экспорт, импортын хэмжээ буурсан боловч хоёрдугаар улирлын туршид сараар авч үзэхэд эдгээр үзүүлэлтүүд аажмаар нэмэгдсэн байна. Энэ нь гэхдээ дотоодын эдийн засаг сэргэж байгаа гэхээсээ илүү зэсийн үнэ нь аажмаар өсч байгаатай илүү холбоотой юм. Хоёрдугаар улиралд экспорт улам их байх боломжтой байсан боловч 6 дугаар сард алтны экспорт хийгдээгүй тул экспортын үнийн дүнгийн хэмжээ илүү өндөр байж чадсангүй.

Эдийн засгийн хямралын үед зарим улс орнууд хөршөө тонох бодлого буюу импортын татвараа өсгөх, татварын бус арга хэмжээ зэрэг дотоодын зах зээлээ хамгаалах бодлого хэрэгжүүлдэг. Манай улсын хувьд протекционист бодлого явуулаагүй байгаа. Ер нь богино хугацаанд үр дүнгээ өгөх гадаад худалдааны бодлого манай улсын хувьд хэрэгжүүлэх боломжгүй юм. Дотоод зэх зээлээ хамгаалах бодлогын сөрөг үр дагавар нь давамгайлах тухай бид өмнөх улирлын тайланд дурьдсан. Хямралыг даван туулах бодлого гэхээсээ илүү гадаад худалдааны урт хугацааны гол бодлого

болох экспортыг дэмжих бодлогыг эрчимжүүлэх хэрэгтэй байна. Манай улс зарим түүхий эдийн үйлдвэрлэлээр харьцангуй давуу талтай. Гэхдээ боловсруулсан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зарим төрлүүдээр харьцангуй давуу талыг бий болгох хэрэгтэй байна. Тухайлбал, зөвлөгөө, судалгаа, даатгал, аялал жуулчлал, ложистик, боловсрол, урлаг соёлын экспортыг урамшуулах, олон улсын түвшинд сурталчлах зэрэг төрөл бүрийн дэмжлэгийг үзүүлж болно. Ингэхийн тулд экспортын өртгийг бууруулах нь хамгийн чухал. Энэ нь юуны өмнө тээвэр болон трансакцийн бусад зардлыг бууруулахад чиглэх ёстой юм. Гадаад худалдаанд үзүүлэх институцийн дэмжлэгийг зөвхөн төрийн байгууллага бус, мөн төрийн бус байгууллагууд тухайлбал Худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг байгууллагууд давхар хийж байхаар зохицуулж болох юм.

Нийт эрэлтийн талаарх бодлого ба ОУВС – тай хэрэгжүүлж буй хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газрын ОУВС-тай 2009 оны 4 дүгээр сард тохирсон хөтөлбөр нь 18 сарын хугацаанд хэрэгжих бөгөөд Стэнд-бай гэж нэртэй. Иймэрхүү төрлийн хөтөлбөрийн гэрээг ОУВС эдийн засгийн огцом хямралтай тулсан орнуудтай богино хугацаанд хийдэг. Энэхүү гэрээний гол зорилго нь тухайн улсад богино хугацаанд үүссэн гадаад төлбөрийн хомсдлыг нөхөхөд оршино. Манай улсын хувьд нэг талаас валютын ханшны огцом хэлбэлзэл бий болсноор эдийн засгийн тогтворгүй байдал даамжрах төлөвтэй болсон. Нөгөө талаас, манай улс руу экспортоор орж ирдэг валютын урсгал эрс багассан учраас импортоо гадаад валютын нөөцөөрөө санхүүжүүлэх болсон. Энэ хоёр хүчин зүйлийн улмаас тус хөтөлбөрийг манай бодлого боловсруулагчид хэрэгжүүлэхээс өөр гарцгүй болжээ.

Тэгвэл энэхүү хөтөлбөрийн гол ач холбогдол юундаа байна вэ гэдэг асуулт гарч байна. Өнөөгийн ОУВС-тай гэрээ байгуулсны хамгийн гол ач холбогдол нь Засгийн газарт

хөрөнгийн эх үүсвэрийг олон улсын санхүүгийн байгууллагууд болон донор орнуудаас олох боломжийг нээж өгч байгаад оршиж байгаа. Одоогийн байдлаар 160 сая ам. доллартай тэнцэхүйц хөрөнгийн эх үүсвэрийг Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк, Япон улсын Засгийн газар ирэх 2 жилийн хугацаанд олгохоор амлаад байна. Нөгөө талаас хөтөлбөрийн дагуу Засгийн газар болон Монголбанк тодорхой бодлогын өөрчлөлт хийх үүрэг хүлээсэн.

Сүүлийн жилүүдэд ОУВС аливаа нэг орны эдийн засгийн онцлог нөхцөл байдлыг үл харгалзан бүх орнуудад нэг төрлийн хөтөлбөрийг авч хэрэгжүүлж байсан нь үр дүн өгөхгүй байна гэсэн шүүмжлэлд өртөөд байгаа. Өнөөгийн санхүү, эдийн засгийн хямралтай байгаа үед ОУВС тус шүүмжийг хэрхэн тусган авч манай улсад ямар бодлогын зөвлөмж өгч байгаа, өмнөх зөвлөмжүүдээс юугаараа онцлог, өөр байна вэ гэдэг асуудал онцгой анхаарал татаж байна.

2009 оны эхний улирлын тайланд бид иймэрхүү төрлийн хөтөлбөр ашиг сонирхлын зөрчлөөс болж тэр болгон амжилтанд хүрэхгүй байх боломжтой гэж тэмдэглэсэн. Тухайн тайлан хэвлэгдэх үед манай Засгийн газар ОУВС-тай хөтөлбөр үндсэндээ тохирсон байсан бөгөөд Монголбанк бодлогын хүүгээ огцом өсгөж, мөнгөний хатуу бодлогоо улам чангаруулсан. Хүү өсгөсөн нэг шалтгаан нь бодит хүүг эерэг болгох шаардлагатай гэж Монголбанк зарласан. Бодлогын хүүг өсгөснийг ОУВС дэмжиж байгаагаа ч илэрхийлсэн. ОУВС хэдийгээр дотоод өөрчлөлт хийж байгаа ч манай орны өнөөгийн нөхцөл байдалд тохирсон ямар бодлогын өөрчлөлт гарсан бэ гэдэг нь тэр бүр тодорхой биш байна. Зээлийн болоод хадгаламжийн бодит хүүг эерэг түвшинд барих хатуу зарчмыг баримталсаар ирсэн нь өмнө хэрэгжүүлж байсан хөтөлбөрүүдтэй нэгэн адил байгааг тэмдэглэх нь зүйтэй. Тухайн үед бид бодит хүүг богино хугацаанд заавал эерэг түвшинд хүчээр аваах шаардлага байхгүй гэж өмнөх тайландаа тэмдэглэж байсан.

Тухайлбал, Монголбанк зөвхөн бодит хүүг эерэг байлгахыг удирдлагаа болгож бодлогын хүүгээ өсгөх нь буруу гэж тэмдэглэсэн. Нөгөө талаас, одоогийн хэрэгжүүлж буй Стэнд-бай хөтөлбөр нь биелүүлэхэд хүндрэлтэй тодорхой тоон зорилтууд багатай, Засгийн газар болоод Монголбанкны үйл ажиллагаанд шууд хутгалдан орох заалтууд цөөн, цомхон, хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь тодорхой байгаа нь нааштай өөрчлөлт болжээ.

2009 оны 6 дугаар сард Монголбанк бодлогын хүүгээ бууруулах эхний арга хэмжээнүүдийг аваад эхэлсэн. Бодлогын хүү буурна гэдэг нь банкны сектор дахь илүүдэл нөөцийг төв банк өөр дээрээ татан авахгүй гэсэн үг юм. Тэгэхээр тэр илүүдэл нөөц зээл хэлбэрээр эдийн засаг руу гарна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, энэ нь мөнгөний хатуу бодлого суларч байгаагийн эхний дохио. Мөнгөний бодлогоо бага хэмжээгээр сулруулах шалтгаан нь инфляцийн түвшин 5 дугаар сарын эцсийн байдлаар 7.3 хувьтай болсонтой холбоотой. Бид мөнгөний бодлого, санхүүгийн салбарын өнөөгийн байдлын талаар “Санхүү, эдийн засгийн хямрал ба Монгол Улсын санхүүгийн зах зээл: 2009 оны эхний хагас жилийн тайлан”-д дэлгэрэнгүй авч үзэн өөрсдийн үнэлэлт, дүгнэлтээ өгсөн.

Өнөөгийн ОУВС-тай зөвшилцөж, хэрэгжүүлж байгаа мөнгөний бодлогыг аваад үзэхэд төөрөгдөлд оруулахаар үйл ажиллагаанууд харагдаж байна гэдгийг бид тус тайланд тэмдэглэсэн байгаа. Юуны өмнө, Монгол Улсын гадаад валютын нөөцийг удирдаж, мөнгөний бодлого явуулдаг Монголбанк болоод төсөв, сангийн бодлого хэрэгжүүлдэг Засгийн газрын хоорондын үйл ажиллагааны харилцаанд анхаарах зүйл байна. Монголбанк нь Засгийн газраас хараат бус мөнгөний бодлого явуулах учиртай. Энэ нь үндсэндээ Монголбанк Засгийн газрын ямар нэг шахалтад оролгүйгээр хараат бус бодлого баримталж үнийн өсөлтийг хязгаарлахад гол анхаарлаа хандуулах учиртай гэсэн үг юм. Гэтэл Монголбанкнаас Засгийн газарт зээл олгоод

байгаа нь Монголбанк Засгийн газраас хараат бус үйл ажиллагаа явуулж чадаж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байна.

Мөнгөний бодлогыг ойлгомжгүй байдалд оруулсан өөр нэг зүйл бол Монголбанкнаас банкуудад зээл олгосон явдал. 2009 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар банкуудад олгосон зээлийн өрийн үлдэгдэл 152 тэрбум төгрөг байна. Мөнгөний хатуу бодлого баримталж буй үед банкуудад зээл олгосон нь хатуу мөнгөний бодлогынх нь эсрэг үйлдэл төдийгүй зарим банкууд, компаниудад шударга бусаар давуу тал олгож байгаа явдал юм. Төв банк аливаа нэг үйлдвэрлэлийн салбар, компаниудад банкуудаар дамжуулан зээл олгох явдал бол өнөөг хүртэл хэвшүүлэх гэж оролдож буй бодлогын тогтолцооны эсрэг үйлдэл болсон гэлтэй.

Монголбанк мөнгөний бодлого явуулахдаа дотоод зөрчил багатай бодлого баримталж, инфляцитай 2-3 жилийн турш тууштай тэмцэх шаардлагатай гэж бид дүгнэж байна. Түүнчлэн, 2009 оны эхний гурван сард валютын ханшны хэлбэлзэл манай мөнгөний бодлогын сул талыг ил гаргасан гэж өмнөх улирлын тайландаа бид тэмдэглэсэн. Санхүү, эдийн засгийн хямрал нэгээр дуусахгүй тул валютын ханшны талаарх байр сууриа Монголбанк тодорхой болгох шаардлагатай байна.

Засгийн газрын ОУВС-тай байгуулсан хөтөлбөрт төсөв, сангийн бодлогыг тодорхойлж өгсөн байгаа. Санхүү, эдийн засгийн хямралын эсрэг Засгийн газрын боловсруулсан төсөв, сангийн бодлого нь үндсэндээ төсвийн хумих бодлогоор тодорхойлогдож байна гэж бид өмнөх улирлын тайланд дүгнэсэн. Тухайн тайлан хэвлэгдэж байх үед ОУВС-тай Стэнд-бай хөтөлбөрийг хараахан эцэслэн тохиороогүй байсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын “Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний төлөвлөгөө” хэрэгжиж байсан юм. Засгийн газрын хэрэгжүүлж байсан тус хөтөлбөр нь 1.5 их наяд төгрөгийн өртөгтэй байжээ. Тус хөтөлбөр нь эдийн засаг

дахь Засгийн газрын оролцоог нэмэгдүүлэх замаар санхүү, эдийн засгийн хямралтай тэмцэх зорилготой батлагдсан. Тухайлбал, банкны салбараар дамжуулан барилгын салбарт болоод малчдад зээл олгох, уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжихэд зориулж дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх, авто зам болоод дулааны цахилгаан станц барих зэрэг томоохон арга хэмжээнүүд төлөвлөгдсөн. Засгийн газрын хэрэглээг ингэж нэмэгдүүлэхийн тулд 1.2 тэрбум ам. долларын санхүүжилтийг гадаад зах зээл дээр Засгийн газрын бонд гаргах замаар олж авахаар тусчээ. Гэвч энэхүү зарлагын өсөлтийг санхүүжүүлэх бодит боломж хязгаарлагдмал байсан учраас энэ хөтөлбөр хэрэгжих боломжгүй болсон. Нөгөө талаас, мөнгөний хатуу бодлогоор дамжуулан нийт эрэлтийг хязгаарлах бодлого баримталж буй үед төсөв, сангийн тэлэх бодлого явуулж нийт эрэлтийг өсгөх бодлого баримтлах нь зөрчилтэй арга хэмжээ болох байсан.

ОУВС-тай тохирсон Стэнд-бай хөтөлбөрт төсөв, сангийн бодлогыг үндсэндээ төсвийн алдагдлыг бага байлгахаар тодорхойлж өгсөн байгаа. 2009 оны 6 дугаар сарын төсвийн тодотголоор Засгийн газрын алдагдлыг 364 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5.8 хувьтай тэнцүү байхаар зааж өгсөн. 2009 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар төсвийн алдагдал 264 тэрбум төгрөг байгаа бөгөөд тайлант оны эцэс гэхэд төлөвлөсөн хэмжээндээ байх эсэх нь тодорхойгүй байна. Төсвийн орлого 826 тэрбум төгрөг, нийт зарлага 1.09 их наяд төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Засгийн газрын зарлага ижил түвшинд байхад Засгийн газрын орлого 20 хувиар буурсан нь төсвийн алдагдал бий болоход нөлөөлжээ.

Төсвийн алдагдлыг дээр дурьдсан олон улсын санхүүгийн байгууллагууд болон донор орнуудаас зээл авах замаар нөхөхөөр төлөвлөсөн. зургаадугаар сарын сүүлээр Дэлхийн Банк эхний ээлжинд 40 сая ам. долларын зээлийг олгохоор шийдвэрлээд байгаа бөгөөд тайлант оны хоёрдугаар хагаст

эдгээр зээлүүдийн дийлэнх орж ирэхээр хүлээгдэж байна. Өнөөдрийн байдлаар эдгээр байгууллагууд төсвийн алдагдлыг нөхөхөд зориулж 160 сая ам. доллартай тэнцэх зээл олгох боломжтойгоо олон улсын байгууллагууд илэрхийлсэн. Засгийн газар үлдэгдэл хөрөнгийг олох боломжтой гэж мэдэгдэж байгаа. Ийнхүү төсөв, сангийн бодлого санхүү, эдийн засгийн хямралын өнөө үед тэлэлт хийх орон зай багатай болсон бөгөөд ОУВС-тай тохирсон хөтөлбөр ёсоор төсвийн алдагдлын хэмжээг тодорхой хувьд барих ёстой болсон.

Сүүлийн жилүүдэд улсын төсөв ДНБ-ий томоохон хувийг эзлэх болсон. 2008 оны эцсийн байдлаар Засгийн газрын зарлага ДНБ-ий 40 хувьтай тэнцэхүйц байгаа нь Засгийн газрын эдийн засагт оролцох оролцоо өндөр байгааг харуулсан. 2009 оны хувьд энэхүү харьцаа төдийлөн буурахгүй байхаар төсөвлөгдөж байна. Ер нь Засгийн газрын эдийн засаг дахь оролцоог багасгаж, хувийн секторын эдийн засагт гүйцэтгэх үүргийг өсгөх нь эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхээс гадна эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоход түлхэц болно гэж бид өмнөх улирлын тайланд дүгнэсэн. Засгийн газар энэ тал дээр дунд хугацааны хөтөлбөр боловсруулж 2011 он гэхэд Засгийн газрын зарлагыг ДНБ-ий 32 хувьтай тэнцүү болтол бууруулахаар төлөвлөж байгаа нь сайн хэрэг. Гагцхүү энэхүү зорилтоо биелүүлэх асуудал л чухлаар тавигдаж байна.

Тэгвэл манай орны төсөв, сангийн бодлогод тулгамдаад байгаа ямар асуудал байна вэ? Өнөөг хүртэл хэрэгжиж байгаа эдийн засгийн мөчлөг дагасан төсөв, сангийн бодлогыг өөрчлөх шаардлагатай байна. Төсөв, сангийн бодлогыг эдийн засгийн мөчлөг болоод уул уурхайн салбарын орлогоос хараат бус байлгах нь зүйтэй гэж бид өмнөх улирлын тайланд тэмдэглэсэн. Тухайлбал, Засгийн газрын зарлагыг жил болгон тодорхой хувиар өсгөж байх тогтолцоонд шилжиж болох талаар дурьдсан. Харин Засгийн газрын орлого эдийн засгийн мөчлөгийг даган өсч буурна. Товчхондоо, төсөв сангийн бодлогын

гол зорилго бол эдийн засгийн өсөлтийн үед хуримтлал бий болгож, түүнийгээ эдийн засгийн уналтын үед хэрэглэж байхаар зохицуулагдахад оршиж байгаа юм.

Энэхүү зохицуулалтад шилжихэд хэд хэдэн анхаарах зүйл гарна. Юуны түрүүнд Засгийн газрын зарлагын өсөлтийг хэрхэн тогтоох вэ гэдэг асуудал. Сүүлийн хэдэн жилд ажиглагдсан шиг жил болгон зарлагын өсөлтийг огцом өндөрсгөөд байвал энэ бодлого үр дүнгээ өгөхгүй. Тийм учраас Засгийн газрын зарлагыг урт хугацааны эдийн засгийн өсөлт болоод манай экспортын гол бүтээгдэхүүнүүдийн үнийн урт болоод дунд хугацааны чиг хандлагад үндэслэн тогтоож өгөх нь зүйтэй.

Засгийн газрын зарлагын өсөлтийг тогтворжуулахтай зэрэгцээд хуримтлалын сан байгуулах ёстой болно. Тэгвэл энэхүү сангийн хөрөнгийг хэрхэн ашиглах вэ гэдэг асуудал гарч байна. Хэрэв хуримтлалын сангийн хөрөнгө тэтгэвэр тэтгэмж, нийгмийн халамж, эрүүл мэнд, боловсрол зэрэг Засгийн газрын зарлагыг санхүүжүүлэхэд зарцуулагдвал энэхүү тогтолцоо нь үр ашиггүй болно. Тийм учраас тус сангийн хөрөнгийг манай улсын валютын нөөцийн удирдлагатай адилаар удирдах боломжтой гэж үзлээ.

Төсөв, сангийн бодлогын үндсэн зарчим нь ийнхүү тодорхойлогдох боломжтой гэж үзлээ. Сангийн яам энэ тал дээр “Төсвийн тогтворжилтийн хууль”-ийн төслийг санаачилж, ОУВС манай улсад яг энэ сэдвээр зөвлөмж өгсөн нь нүдээ олсон арга хэмжээ болжээ. Уг хуулийн төслийн гол агуулга нь бидний дээр дурьдсан зарчим бөгөөд Засгийн газрын төсвийг эдийн засгийн мөчлөг болоод экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн үнийн хэлбэлзлээс ангид байлгах зорилготой юм.

Одоогийн байдлаар энэхүү төсөл нь боловсруулалтын шатанд байгаа бөгөөд бидэнд тус төсөлтэй бүрэн дүүрэн танилцаж, холбогдох яам, газрууд болоод бодлого боловсруулагчидтай санал солилцох боломж цаашид гарч ирнэ. Бид энэхүү хуулийн төслийн талаар дараагийн улирлын тайланд дэлгэрэнгүй

мэдээлэх болно. Ер нь гадаад байгууллагуудын энэ мэт үнэ цэнэтэй зөвлөмжийг сонсч, хүлээн авах нь зүйтэй хэдий ч бид өөрсдийн хувилбараа бодож боловсруулж, санал бодлоо өргөн хүрээтэй солилцох нь маш чухал. Тийм ч учраас Сангийн яам болоод ОУВС энэхүү ач холбогдол өндөртэй хуулийн төсөл дээр олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, ач тусыг нь сурталчлах шаардлагатай байна.

Дүгнэлт

2009 оны хоёрдугаар улиралд дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудын эдийн засаг тогтворжих анхны шинж тэмдэгүүд илэрч эхлээд байна. Гэхдээ хямрал дуусгавар болох хараахан болоогүйгээр үл барам хөгжиж буй ихэнх улс орнуудын байдал сул хэвээр байна. Азийн орнууд энэ хямралд харьцангуй бага өртөж байна. Ялангуяа Хятад болон Энэтхэгийн эдийн засаг өндөр өсөлттэй хэвээр байгаа нь бүс нутгийн жижиг эдийн засагт эерэгээр нөлөөлнө. Тиймээс Монголын эдийн засгийн хувьд эерэг нөлөө өмнөд хөршөөс мэдрэгдэх ёстой. Манай улсаас авдаг экспортын бүтээгдэхүүний хэмжээ энэ оны эхний улиралд нэлээд буурсан байсан бол хоёрдугаар улиралд нэмэгдэх хандлагатай байгаа нь Хятадын эрэлт илүү хүчтэй болж байгаагийн нэг илрэл юм. Цаашдаа БНХАУ дэлхийн томоохон хэрэглээний зах зээл болно гэж үзвэл манай улсын дунд хугацааны төлөв нэлээд сайн байх нь.

Гадаад орчин таагүй хэвээр байхаас гадна дотоодын эрэлт сул хэвээр байна. Үүний үр дүнд манай дотоодын үйлдвэрлэл буурсаар байна. Энэ оны эхний улирлын байдлаар ДНБ 4.2 хувиар буурсан нь сүүлийн олон жил байгаагүй бууралт юм. Хоёрдугаар улиралд үйлдвэрлэл сэргэх хандлага байгаа ч энэ нь хямралын нөлөө суларч буйн шинж тэмдэг гэхээсээ улирлын шинж чанартай өөрчлөлт болов уу. Энэ онд Дэлхийн Банкнаас гаргасан 2.7 хувийн өсөлтийн таамаглал хэрэгжихгүй байх магадлал байна. Оюу Толгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээ хэр түргэн зурагдах,

үүнтэй холбоотой манай эдийн засагт нөлөө нь хэр хурдан мэдрэгдэхээс байдал ихээхэн шалтгаалах нь.

Хямралын эсрэг Засгийн газраас дорвитой арга хэмжээ авч чадаагүй. Нийт эрэлтийг дэмжих макро эдийн засгийн тэлэх бодлого үгүйлэгдэж байгаа хэдий ч ийм бодлого хэрэгжүүлэх орон зай байхгүй талаар бид эхний улирлын тайланд онцлон тэмдэглэсэн. Үнэхээр ч манай Засгийн газрын авсан ганц томоохон бодлого нь ОУВС-тай тохирсон Стэнд-бай хөтөлбөр юм. Тиймээс ч энэхүү тайланд бид энэ хөтөлбөрийн талаар илүү дэлгэрэнгүй авч үзлээ. Стэнд-бай хөтөлбөр нь өртөг багатай гадаад валютын эх үүсвэрийг богино хугацаанд олгож байгаагаар үл барам макро эдийн засгийн бодлогыг өөрчлөхөд тус дэм болох ёстой юм. Нөгөөтэйгүүр бусад донор байгууллага, орнуудын хувьд бодлогын талаар нааштай дохио өгч, зээл тусламжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн билээ. Энэ удаагийн Стэнд-бай хөтөлбөр нь олон нөхцөл заалтгүй, бодлогод хөндлөнгөөс шууд оролцсон зүйл байхгүй учир бас нэг давуу талтай боллоо. Манай Засгийн газрын хувьд хөтөлбөрийн нөхцөл болох үндсэн үзүүлэлтүүдийг сайн биелүүлж байна.

Нэгэнт богино хугацаанд хэрэгжүүлэх бодлогын сонголтууд хүнд учир бидний өгч буй бодлогын зөвлөгөө нь гол төлөв дунд болон урт хугацааны бодлогын асуудлууд юм. Дунд болон урт хугацаандаа манай улс ашигт малтмалын орлогыг хөгжлийн дараагийн шатанд шилжих суурь болгон ашиглах нь зүйтэй юм. Ингэхийн тулд зөв зохистой төсөв, сангийн бодлого хамгийн чухал бөгөөд Засгийн газар үүн дээр тодорхой санаачлага гарган ажиллаж эхлээд байна.